

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 1

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

1.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6-7
2.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналын тухай	7-8
3.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	8-9
4.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	9-10
5.“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	10-11
6.“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	11-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 15 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь, Г.Занданшатар, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар, Л.Оюун-Эрдэнэ.

Нэг.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Төрийн ёслолын хэлтсийн дарга Э.Одмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Байнгын хорооны дарга Н.Энхболд санал хураалтын шинэ төхөөрөмж ажиллахгүй байгаа тул гар өргөж санал хураалт явуулах талаар мэдэгдэв.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “ ... дүгээр сарын ... –ний” гэснийг “06 дугаар сарын 15-ны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналын тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Ц.Цолмон оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Цэдэвийн Цолмонг нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх

Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. *“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн газрын ахлах шинжээч Д.Мөнхжаргал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Статистик судалгааны хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал, Улсын Их Хурлын гишүүн асан Н.Тогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Г.Ганболд нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Энхболд үг хэлэв.

Н.Энхболд: “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 35 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
14 цаг 15 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Байнгын хороод давхцаад өрөө тасалгаагаа зохицуулж байгаад жоохон оройтож эхэлж байна. Тэгэхдээ гишүүдийн олонх ирлээ. Ирц бүрдсэн тул 2024 оны 05 сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар:

- Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг болно.

- Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал. Монгол Улсын Их Хурлаас нэг хүн нэр дэвшүүлдэг. Түүний нэрийг өнөөдөр хэлэлцэнэ.

- “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төсөл,

- Мөн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

- “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Энэ Төрийн албаны зөвлөлтэй холбоотой итгэлцүүр байгаа.

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай. Засгийн

газраас өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе. Ажлын хэсгийг оруулаарай.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Батрагчаа, Төрийн ёслолын албаны дарга Одмөнх нар оролцоно.

2 заалттай хуулийн төсөл байгаа. Бид нар зүйл бүрээр хэлэлцэх ёстой.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр би нэг санал оруулчихъя.

Энэ мөрдөх хугацааг нь тавиагүй орж ирсэн юм. Тэгээд Тамгын газартай ярьж, зөвшилцөж байгаад төслийн 2 дугаар зүйлийн дүгээр сарын тэдний өдөр гээд тов тавиагүй байсныг 6 дугаар сарын 15-ны өдөр гэж өөрчлөх саналыг оруулж байна.

Энэ саналтай холбогдуулж асуух, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл төслийн 2 дугаар зүйлийн ... сарын ...- ны гэснийг 6 дугаар сарын 15-ны өдөр гэж өөрчлөх. Гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалтаа ингэнэ шүү. Энэ нөгөө шинэ юутай юм, дарга аа. Тэгээд энэ дээр бас жоохон асуудлууд тэгширч, жигдэрч гүйцээгүй байгаа. Тийм учраас гар өргөөд санал хураачихъя.

Санал хураалтыг дэмжье. Санал хураалт.

7 гишүүн, 11-ээс 8. Тийм байна. Бямбацогт гишүүнийх яагаад орохгүй байна, орсон уу. 11 болох ёстой доо. Эхлээд саналуудаа хураачихъя.

11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, санал дэмжигдэж байна.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Санал, дүгнэлтийг Ганболд гишүүн унших уу. Одоо жоохон нөгөө дэвшсэн улсуудаа энэ тэр дээр жоохон гаргая даа. Энэ удаад.

Ганболд гишүүн санал дүгнэлт уншъя.

14.19 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай.

Хуулиар Их Хурлын даргын зүгээс, Их Хурлын нэрийн өмнөөс нэр дэвшүүлэх ёстой. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танилцуулна.

Нэр дэвшигчийг оруулаарай.

Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон онол практикийн болон хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ажилласан мэдлэг, ур чадвар, дадлага туршилагыг үндэслэн

Цэдэвийн Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэхээр Улсын Их Хурлаас санал болгож байна.

Цэдэвийн Цолмон нь 1973 онд төрсөн. 1988 онд Нийслэлийн 10 жилийн 52 дугаар дунд сургуулийг төгссөн. 1993 онд ОХУ-ын Омск хотын Технологийн техникум, 94-98 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2003 онд ИБУИНВУ-ын Эксетерийн их сургуулийн Хууль зүйн мастер, 2014 онд АНУ-ын Нью-Йорк хотын Колумбийн Их сургуулийг Хууль зүйн мастераар тус тус дүүргэсэн.

Цолмон нь 1993-аас 94 онд Улсын Их Хурлын Тамгын газарт мэргэжилтэн, 1998-2001 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, 2004 оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, 2004 оноос 2013 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, 2014 оноос 2016 онд Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч, 2016-2019 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2020-2022 онд Эрдэнэс Монгол ХХК-ийн дэд захирлаар ажилласан. Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч. Монголын ХАҮТ-ын дэргэдэх арбитрын арбитрч ийм төрийн ажлын туршилагатай, онол практикийн мэдлэг ур чадвартай хуульч хүн.

Цолмон нь төрийн албаны Тэргүүн түшмэлийн Тэргүүн зэргийн цолтой, орос англи хэлний мэдлэгтэй. Цолмон нь МУИС-д эрдэм багш, ЭША-аар ажилласан ийм онол практикийн мэдлэгтэйгээс гадна хууль тогтоох байгууллага Улсын Их Хурлын Тамгын газарт Ерөнхий нарийн бичгийн дарга болон бүх шатад ажилласан туршилагатай.

Мөн гүйцэтгэх эрх мэдлийн салбарт Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажилласан туршилагатай, бас

шүүх эрх мэдлийн салбарт ажилласан туршлагатай, мэргэшсэн хуульч юм.

Ийм учраас Цолмонг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал болгож байна. Саналыг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Занданишатар даргад баярлалаа.

Занданишатар даргын танилцуулгаас болоод нэр дэвшигч Цолмонгоос асууж, асуулт тавьж, хариулт авч болно. Үг хэлж болно. Гишүүд нэрээ өгөх үү. Байхгүй юу.

Асуулт асуух, үг хэлэх гишүүн алга байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Цэдэвийн Цолмонг нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Түрүүн горимоо гаргаад дэмжсэн. Гараа өргөж санал хураалт явна. Дэмжиж байгаа хүмүүс гараа өргөө.

11-ээс 8 гишүүн дэмжлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг гаргана. Үүний дагуу Их Хурлын дарга захирамж гаргах ийм дэгтэй.

Асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хороогоор дэмжигдсэн Цолмонд баяр хүргэе. Цолмон амжилт хүсье. Эдний ээж намайг намд элсүүлж авч байсан байхгүй юу, СБД-т байхдаа.

14.24 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Энэ Ерөнхий прокурорын газраас санал ирсэн байгаа. Энэ танилцуулчихъя.

УЕПГ-ын аймаг, нийслэлийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга нь Монгол Улсын Их Хурлын 19 оны 8 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан албан тушаалын ангилал, зэрэглэлийн эрхэлсэн түшмэл ангиллын АА-5 зэрэглэлд хамааран үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн албаны зөвлөлөөр албан тушаалын тодорхойлолт батлуулахтай холбогдуулан албан тушаалын ангилал, зэрэглэлийн нэршилд өөрчлөлт оруулах шаардлага бий болоод байна.

Монгол Улсын Их Хурлын 19 оны 18 дугаар тогтоолын УЕПГ гэсэн баганын АА-5 зэрэглэлд хэлтсийн дарга гэсэн албан тушаал тусгагдаагүй. Зөвхөн тасгийн дарга, ахлах референт гэж тусгасан үндэслэлээр Тамгын хэлтсийн дарга нарын албан тушаалын тодорхойлолт тухайн үед батлагдаагүй. Тамгын хэлтсийн дарга гэсэн албан тушаалын нэр томъёо Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн 16.4.13 дахь заалтад тусгагдаж хуульчлагдсан учраас өөрчлөх боломжгүй байгаа.

Иймд Их Хурлын 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан албан тушаалын ангилал, зэрэглэлийн эрхэлсэн түшмэл ангиллын УЕП гэсэн баганын АА-5 зэрэглэлийн “Тасгийн дарга” гэсний өмнө “Прокурорын газрын хэлтэс” гэж, дэс түшмэл ангиллын АА-9 зэрэглэлийн “ахлах мэргэжилтэн” гэсний өмнө “Прокурорын газрын” гэсэн нэмэлт оруулах саналыг ирүүлсэн байгаа.

Мөн Төрийн албаны зөвлөлөөс энэ саналыг зарчмын хувьд дэмжсэн ийм албан тоотууд ирсэн. Ингээд үүний дагуу

тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж байгаа.

Үүнтэй холбогдуулж асуух гишүүн байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл тогтоолын төслөө танилцуулаадахъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай. Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын УЕПГ гэсэн баганын АА-5 зэрэглэлийн “Тасгийн дарга” гэсний өмнө “Прокурорын газрын хэлтэс” гэж, АА-9 зэрэглэлийн “ахлах мэргэжилтэн” гэсний өмнө “Прокурорын газрын” гэж тус тус нэмсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн гишүүд гараа өргөө. Санал хураалт.

11-ээс 8 дэмжлээ.

Байнгын хорооноос санал, дүгнэлт гарна. Санал, дүгнэлтийг Бямбаа гишүүн танилцуулчих уу? Бямбацогт.

Түрүүчийнхийг Ганболд гишүүн танилцуулсан.

14.27 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тэр тогтоолоо өг дөө. Дараагийнх нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Төрийн албаны зөвлөлийн Төрийн албаны Ёс зүйн хорооноос тус тус саналууд ирүүлсэн. Утгыг нь уншихъя.

Төрийн албаны тухай хууль, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж заасан. Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажлын ачаалал, хариуцлагыг харгалзан үзэж, нийгмийн нотолгоог хангах зорилгоор тогтоолын төслийг боловсруулж хүргүүлж батлуулах саналтай байна.

Ийм учраас Их Хурлын 19 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, зохих шийдвэрийг гаргаж өгөхийг хүсье гэсэн Цэдэвсүрэн даргын гарын үсэгтэй бичиг. Энэ чинь хоёулаа хамт л явчих билүү?

Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжид Ёс зүйн хорооны гишүүдийн ажиллах нөхцөл баталгаа, цалин хөлсний зохицуулалт бүрэн шийдвэрлэгдээгүй байгаа нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан төрийн албан тушаалтны зэрэг, зиндаа түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлийн Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүний ангилал зэрэглэлтэй дүйцүүлэн тогтоох, улмаар цалин хөлсний итгэлцүүрийг мөрдөх

хүрээнд саналаа ирүүлсэн асуудлыг шийдвэрлэж өгөхийг гэсэн байгаа.

Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 4 дүгээр тогтоолоор батлагдсан Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэмд Ёс зүйн хорооны ажлын алба нь Төрийн албаны зөвлөлийн ажлын албатай ижил байхаар батлагдсан. Ийм учир шалтгаанууд байгаа учраас өнөөдрийн энэ тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж байна.

Төслийг би уншаад танилцуулъя.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-IVA”-ийн захиргааны албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн дарга гэж нэмсүгэй.

2. “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-VA”-ийн захиргааны албан тушаалын “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга” гэснийг “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэж өөрчилсүгэй.

3. “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол

Улсын Их Хурлын 19 оны 02 сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-VA”-ийн захиргааны албан тушаалд Ёс зүйн хорооны дарга гэж, “ТӨ-VIA”-ийн захиргааны албан тушаалд Ёс зүйн хорооны гишүүн гэж тус тус нэмсүгэй.

4. “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-VIA”-ийн захиргааны албан тушаалын Төрийн албаны зөвлөлийн гишүүн гэснийг хасав гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Төсөлтэй холбогдуулж асуух гишүүн байна уу? Алга байна.

Уг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Саяын уншиж танилцуулсан тогтоолын төслийг дэмжэе гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

11-ээс 8 гишүүн дэмжиж байна.

Санал, дүгнэлтийг Сарангэрэл гишүүн.

14.32 цаг

Дараагийн асуудал. Одоо хоёрхон асуудал байна.

“Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя.

Үндсэндээ саяын гаргасан тогтоолуудтай үргэлжлэл нь болж гарч байгаа тогтоол гэж ойлгож болно. Тогтоолын батлах үндэслэлийн талаар Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос ирүүлсэн саналуудыг танилцуулсан.

Ингээд би тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүний албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг хавсралтаар баталсугай.

Итгэлцүүр.

Д/д	Албан тушаал	Албан тушаалын зэрэг зиндаа, адилтгах албан тушаалын зэрэглэл	Цалингийн итгэлцүүр
1	Төрийн албаны зөвлөлийн дарга	ТӨ-IVA	1.95
2	Төрийн албаны зөвлөлийн гишүүн	ТӨ-VA	1.85
3	Яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын сарын цалингийн хамгийн өндөр шатлал		1.00

гэсэн итгэлцүүртэй байгаа.

Энэ тогтоолыг асуух, санал хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Саяын уншиж танилцуулсан тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

11-ээс 8.

Санал, дүгнэлтийг Жаргалмаа гишүүн уншина. Байнгын хороонд.

14.34 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 1 асуудал байна.

Монгол Улсын Засгийн газраас “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцүүлээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа.

Чуулганы хуралдаанд манай Байнгын хороо хэлэлцэж оруулах ёстой. Төслийг, холбогдох материалыг гишүүдэд тараасан байгаа.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай. Тийм, нөгөө аймаг, сумдад яаж, хаана нь юуг хөгжүүлэх вэ, аль бүсэд юу, аль нь төв байх вэ гэсэн ийм үзэл баримтлалыг оруулсан. Материал энд байна. Үзэх үү. Ганболд гишүүнд харуулчих даа. Ядаж аймаг хараадахъя.

Засгийн газрын танилцуулгыг Бямбацогт сайд хийнэ.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын дарга, бүлгийн дарга, эрхэм гишүүд та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд Монгол Улсын Их Хурал баталсан байдаг. 23 жилийн хугацаа өнгөрсөн. Өнгөрсөн хугацаа нь үндсэндээ хамгийн хэрэгжээгүй, хамгийн бүтэл муутай байсан Улсын Их Хурлаас баталсан

тогтоолуудын нэг бол Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал.

Тэгээд л тал талдаа бүс болгон төвтэй байх ёстой, аймаг болгон бүсийн төв болно гээд. Тэгээд л тал тал тийш нь чангааж, ингэж явсаар байгаад өдий болсон. Тэгээд тийм болохоор бас энэ дэлхий нийтийн чиг хандлага, баруун бүс нутаг, зүүн бүс нутаг, энэ төвийн бүс нутаг, Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвтэй байгааг олон таталцлын төвтэй болгох, бүс бүрдээ бас таталцлын төвтэй болгох. Энэ бодлогын хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газар боловсруулж, Их Хуралд өргөн барьж байгаа.

Тус үзэл баримтлал нь 6 бүлэг, 1 эрхэм зорилго, 7 зорилго 217 зорилт, арга хэмжээг тусгахаар төлөвлөсөн.

Монгол Улсыг эдийн засгийн, хангайн, баруун, хойд, төвийн, зүүн, говийн, Улаанбаатарын гэсэн 7 бүсчлэлийн тогтолцоог хөгжүүлэхээр тодорхойлсон. Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг, баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг, хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл аймаг, төвийн бүсэд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг, зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг, говийн бүсэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг, Улаанбаатарын бүсэд Улаанбаатар хот болон дагуул хотууд гэсэн ийм 7 бүсчлэл байхаар тодорхойлж байна.

Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон.

Бүс нутгийн хөгжлийн орчин үеийн онолын чиг хандлагад үндэслэх,

Бүс нутгуудын бас онцлог давуу талуудыг бас нээж илрүүлэх,

Бүс орон нутгийн эдийн засгийн хөгжлийн чиг үүрэг, оновчтой тодорхойлох,

Байгалийн нөөцийн баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх энэ бодлого.

Мөн бас үйлдвэрлэл, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжих.

Бүс орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлэх,

Бүс дамнасан салбар хоорондын уялдааг хангасан стратегийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх,

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт бусад санхүүгийн эх үүсвэрүүдийг бас оновчтой хуваарилах,

Татвар санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлэх. Ялангуяа энэ маш чухал асуудал байгаа. Алслагдсан бүсүүдийн хөнгөлөлт, нэмэгдлийн асуудлыг бас тодорхойлж хэрэгжүүлэх.

Бүс нутгийн хөгжилд оролцох талуудын хамтран ажиллах сонирхлыг дэмжих,

Тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсүүдийг хөгжүүлэх,

Дэд бүтцийн нэгдсэн ухаалаг сүлжээг байгуулах,

Бүс нутгийн эдийн засгийн интеграцад бас нэгдэх, зах зээлийг тэлэх.

Орчин үеийн шинэ суурьшлын бүсүүд, хотуудыг байгуулах,

Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдэл ядуурал бууруулах, орон нутагт ажиллаж амьдрах бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвийг задлах, орон нутагт бас нутагтаа сайхан ажиллах, амьдрах бололцоо боломжийг бүрдүүлэх гэсэн ийм бас зорилтуудыг хэрэгжүүлэхээр өнөөдөр бас энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Монгол Улсын Засгийн газар боловсруулж Их Хуралд өргөн барьсан юм.

Тэгээд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Байнгын хорооныхоо эрхэм гишүүдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Бямбацогт сайдад баярлалаа.

Ер нь энэ асуудал бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад төрийн бодлого тогтвортой залгамж чанартай байх тухай үзэл баримтлалыг агуулгыг тусгасан.

Дараа нь Сонгуулийн хууль, бүсчилсэн хөгжлийн тухай асуудал. Сонгуулиа бүсчилсэн тойргоор явуулах, түүнтэй уялдуулж улс орноо хөгжүүлэх, хөгжлийн бүсүүдээ тодорхойлох. Энэ удаа дараа ар араасаа дэс дараатай хийгдэж байгаа энэ ажлуудын логик үргэлжлэл болж өнөөдөр Засгийн газраас “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын төсөл орж ирж байна гэж Байнгын хорооны гишүүд ойлгож байгаа.

Энэ асуудлыг хэлэлцэхээр хуралдаанд Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Тавинбэх, түрүүн харагдаж байсан, яасан. Эдийн засаг хөгжлийн яамны Бүс орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр, Техникийн ухааны доктор, Улсын Их Хурлын гишүүн асан, манай Тогтох гуай, Эдийн засгийн хөгжлийн яамны Бүс орон нутгийн хөгжлийн

бодлогын газрын ахлах шинжээч Мөнхжаргал, Бямбацогт сайд нар оролцож байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Судалгааны хэлтсийн дарга Дэлгэржаргал ийм улсууд оролцож байна.

Танилцуулгатай холбогдуулж асуух гишүүн байвал нэрээ өгье. Ганболд гишүүний нэрийг. Оюунчимэг, Ганболд.

Оюунчимэг гишүүний микрофон өгье.

М.Оюунчимэг: Ингээд жоохон шахуу цагт чухал, чухал хуулийн төсөл, тогтоолууд орж ирж байна л даа. Ялангуяа сүүлийн үед энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай холбоотой тогтоол гарна гэж байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэлэлцүүлэг явж байгаа. 20 минутын хот гээд яриад байгаа. Шинэ хоршоо гээд яриад байгаа. Газартай холбоотой гээд ингээд хэд хэдэн яг энэ нэг багц хуулиуд ингээд орж хэлэлцэгдээд явж байна л даа.

Тэгээд энэ хуулиудын маань уялдаа холбоог хангахгүй бол дараа нь аль нь эх нь, алийг нь баримтлах юм, алийг нь баримтлахгүй юм эсвэл хоорондоо уялдаа холбоо зөрчилдөх зүйлүүд гардаг шүү дээ, манай дээр. Мааш олон хууль гарчихдаг. Ялангуяа энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Бүсчилсэн хөгжлийн энэ үзэл баримтлалтай тогтоолтой холбоотойгоор зөрчилдөх зүйлүүд нэлээд их байгаа. Өөр өөр юмнууд байгаа. Ямар ч байсан 2001, 2003 оны бүсчилсэн хөгжлийн тогтоолыг хүчингүйд тооцоод явчихна. Угаасаа энэ цаг хугацааны хувьд хугацаа нь бараг дуусчихсан гэж хэлж болно, тийм ээ?

Одоо тэгэхээр энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Төрийн байгуулалтын байнгын хороо дээр эртээд бараг санал хураалт нь явагдаад удахгүй чуулганаар орох гэж байгаа.

Тэгэхээр бүсчилсэн хөгжлийн энэ дээр Улаанбаатар хот болон түүний дагуул хотууд гээд орж ирж байна. Нөгөө 20 минутын хот гээд төсөл яваад байгаа. Үндэсний орон сууцжуулах хөтөлбөрийг бас үүнтэй уяна гэж яриад байгаа.

Тэгэхээр зохицуулалтуудыг бүгдийг нь уншаад энэ нь яг үүнтэй уялдана, энэ заалт нь үүнтэйгээ нийцэж байгаа гэдэг байдлаар та бүхэн маань хуулийг нийцүүлэх тал дээр яаж ажилласан бэ гэсэн асуулт байна. Тэгээд дараа нь хариулт авъя.

Н.Энхболд: Эдийн засгийн хөгжлийн яам Эрдэнэбаяр 2 дугаар микрофон. Тогтоолын төсөл шүү.

Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр асуултад хариулъя.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн ажлын хэсэгт Эдийн засгийн яамнаас бас орж ажилласан байгаа. Тэгээд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд улсын зэрэглэлтэй хот болгох энэ судалгаа хийгдээд энэ ажлын хэсэг рүү Эдийн засаг, хөгжлийн сайдын гарын үсэгтэйгээр хүргүүлсэн. Мөн ажлын хэсэг дээр саналыг нь хэлэлцсэн байгаа.

Тэгээд энэ дээр Ховд, Улиастай, Даланзадгад, Арвайхээр, Дархан, Чойбалсан, Сайншанд гэдэг хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгохоор хуулийн төсөлд санал хүргүүлж, энэ нь дэмжигдээд явж байгаа гэж ойлгож байгаа.

Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал маань өөрөө 7 бүстэй байгаа. Улаанбаатарын бүс гэж байгаа. Энэ дотор 20 минутын хот гэдгээр яг нийслэлээсээ өргөн барьж байгаа төсөлтэй адил агуулгаар оруулсан. Нийслэлийн саналыг авч тусгасан. Шат дараалалтай бүсчилсэн хөгжлийн форумуудыг 2 дугаар сард, 3 дугаар сард,

4 дүгээр сард улсын хэмжээнд зохион байгуулсан. Улаанбаатарын бүсчилсэн хөгжлийн форум болсон.

Тэгээд энэ дээр 2 байгууллага хамтарч, төслөө нягт уялдуулсан байгаа.

Н.Энхболд: Тэгээд хамгийн гол нь Эрдэнэбаяр дарга аа, энэ ар араасаа орж ирж байгаа ерөнхий 1 бодлогын хүрээнд явж байгаа юмнууд чинь хоорондоо зөрчилдөхгүй биз. Бие биетэйгээ нийлж байгаа биз л гэж асуусан шүү дээ, тийм ээ.

Ганболд гишүүний микрофоныг өгье.

Г.Ганболд: Тэгээд яах юм, энэ аймгуудаа дотор нь дахиад бас бүсчлэх юм уу? сумууд аа. Одоо энэ орон нутгийн хөгжлийн төв гээд нэг 4 сумын дунд нэг сум нэр зоочихсон байна л даа. Өвөрхангай дээр жишээлэх юм бол Баруунбаян-улаан сум Гучин-Ус руу юугаараа ч харьяалагдахгүй. Зүгээр хол. Аймаг орохоос хол. Тэгээд үүнийг хэнээс асууж, энэ хэдэн сумыг нь тогтоосон юм.

Тэгээд энэ сумууд нь яаж хөгжих юм, тэр аймаг дотроо бүс болоод тэр нэрийг нь тавьчихсан 5, 6 сумыг нь түлхүү хөгжүүлэх юм уу. Түүнд орон нутгийн хөгжлийн төв гээд юугаараа зангидагдах юм, засаг захиргаагаараа юм уу. Яг юугаар зангидагдах гэж байгаа юм бэ гэдэг нь өөрөө сонин байна.

2 дугаарт нь, энэ Жишээлбэл, Чингис хот, Чойр хот, Мандалговь хот, Арвайхээр хот чиглэлийн авто замын бүсэд ноогдох хэсгийг барина гэдэг нь яг юу гэж байгаа юм? Ноогдох хэсэг гэдгийг нь яг алийг нь хэлээд байгаа юм.

Эсвэл бас нэг энэ Шивээ хүрэн чиглэлийн төмөр замын ноогдох хэсгийг нь барина гэдэг нь яг юуг нь хэлээд байгаа юм? Тэгээд би энэ үзэл баримтлалаас ингээд нэг ойлгож байгаа

юм бол дахиад л бас нэг аймаг дотор нь хэдэн сум, сумаар нь бүс болгоод нэг сумуудыг нь арай түлхүү хөгжүүлэх гэж байгаа юм шиг юм хийчихсэн. Тийм.

Тэгээд энэ үзэл баримтлал чинь эсвэл ерөөсөө дотор нь дахиад нэг аймгаа сумуудаар хуваах юм шиг. Тэгээд л ард нь ерөөсөө 1 хэдэн яригдаж л байсан хэдэн юм байна шүү дээ. Энэ одоо үзэл баримтлал гээд өмнөхөөсөө надад ялгарах юм юу ч алга.

Н.Энхболд: Эрдэнэбаяр.

Д.Эрдэнэбаяр: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бас боловсруулах хүрээнд нэлээдгүй олон ажлын хэсэг гарч ажилласан. Тэгээд Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй бас энэ онол арга зүйн хүрээнд ажилласан.

Мөн Барилга, хот байгуулалтын яам дээрээс Барилгын хөгжлийн төв дээр хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төсөл боловсруулах энэ ажил хийгдсэн байгаа.

Өмнөх 2001 оны бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр бүлэг, суурины тогтолцоо гэдэг энэ асуудлыг бас тухайн үед хэлэлцэж, Улсын Их Хурлаар баталж байсан байгаа. Энэ удаа үүнийг 119 шалгуур үзүүлэлтийг 330 сумын түвшинд тооцоод, тээвэр логистикийн хувьд тэр бүсэд байгаа түүхий эдийг дотоод, гадаадын зах зээл дээр хүргэх хамгийн оновчтой дөт энэ байршилуудыг тодорхойлж, энэ дотор оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл мах, сүү, ноос ноолуур, байгалийн дагалдах түүхий эд, малчид, тариаланчдын гар дээр байгаа энэ хоршоодыг бас үе шаттайгаар дэмжих, дэд бүтцээр холбох ийм агуулгаар бид нар энэ удаа оруулж ирсэн байгаа.

Тэгээд энэ бол шинэ биш. Өмнөх 2001 онд ч гэсэн бүлэг, суурины тогтолцоо гээд явж байсан. Барилга,

хот байгуулалтын тухай хууль дээр ч гэсэн хүн амын нутагшил, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. 330 сум руу тарааж хөрөнгө оруулалт хийгээд байгаа нь өөрөө бас их үр дүнгүй болж байна гэдэг энэ агуулгаар бид нар үүнийг тооцож оруулсан байгаа.

Дэлхий нийтийн жишиг дээр ч гэсэн өсөлтийн төв буюу хамгийн нэн тэргүүн ээлжид малчид, тариаланчдыг дэд бүтцээр холбох, тэргүүн ээлжид дэмжих, энэ ашигтай байршилуудаа эдийн засгийн эргэлтэд үе шаттайгаар оруулах гэдэг байдлаар бид нар томъёолж байгаа.

Мэдээж энэ хүснэгт дээр байгаа тэр сумын ард байгаа хамгийн дээд талд байгаа сумууд бол дараагийн үе шатад орж ирнэ. Нийтдээ 69-ийг тодорхойлж байгаа. Үүний дараа ахиад 69 гэдэг байдлаар ингээд явах юм байгаа юм.

Н.Энхболд: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга байна.

Ер нь тэр Их Хурал дээр ороод ч гэсэн та нар яг аргачлалынхаа талаар тийм ээ, тэр юмнуудаа сайн хэлнэ биз. Бид нар бас нэг тогтоол гарсан байгаа. Их Хурлаас. Тэр юу вэ гэхээр жишээ нь сая Ганболд гишүүний асуултад хөндөгдөөд өнгөрлөө шүү дээ, энэ чинь.

Сумуудыг дунд нь, заримыг нь ингээд арай илүү төв нь гэж нэрлээд тойруулаад хөгжүүлэх юм уу яах юм гээд. Энэ чинь өөрөө засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжсийн асуудалтай холбогдож яригдаж эхэлнэ. Тийм ээ, Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалынхаа хүрээнд тухай тухайн газруудад санал хүргээд, иргэдээс нь санал авч байгаад тийм ээ, түүний дагуу бас хийгдэх ажлууд нэлээн байгаа шүү дээ. Санаачилга бол Засгийн газраас гарч байх юм биш үү гэдэг нь энэ түрүүчийн

Их Хурлаас гаргасан тогтоол дээр бид нар бас тусгаад өгчихсөн байгаа. Энэ энэ юмнуудаа тэр чуулганы нэгдсэн хуралдаанд ороход бас хамт танилцуулбал илүү ойлгомжтой болж магадгүй шүү гэж бодож байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

11-ээс 9 гишүүн дэмжлээ.

Байнгын хорооноос санал, дүгнэлт гарна. Оюунчимэг гишүүн уншаад танилцуулчих уу.

Ганболд түрүүн нэгийг авчихсан.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа.

Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ